



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2009 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Хүрээлэнг татан буулгах тухай


Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.3 “ж” заалт, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 68 дугаар тогтоолыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Нийслэлийн Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнгийн чиг үүрэг Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газарт шилжсэнтэй холбогдуулан тус хүрээлэнг татан буулгасугай.

Хоёр. Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Г.Мөнхбаяр/-д даалгасугай.



ДАРГА

 Т.БИЛЭГТ